



**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ**

2019 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 368

Улаанбаатар хот

Сургалтын хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын 3.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Автотээврийн хэрэгслийн бүртгэгч нарт зориулсан сургалтын хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан хөтөлбөрийн хүрээнд сургалт зохион байгуулахыг Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Г.Гантулга/, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ /Б.Гүрсоронзон/-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т даалгасугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С. БАТБОЛД



Төрийн нарийн бичгийн даргын
2019 оны 12 дугаар сарын 02 өдрийн
368 тоот тушаалын хавсралт



АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТНҮҮДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Сургалтын зорилго:

Автотээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагааг хариуцсан мэргэжилтнүүдийн хууль, эрх зүй, дүрэм, журам, стандарт, нормативын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 192 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ын хэрэгжилтийг хангуулахад оршино.

Сургалтын хамрах хүрээ:

Автотээврийн хэрэгслийн бүртгэл хариуцсан мэргэжилтнүүд

Сургалтын хугацаа:

Нийт 17 цаг

Сургалт зохион байгуулах байгууллага: Шинжлэх Ухаан Технологийн Их сургуулийн харьяа Механик, тээврийн сургууль

| д/д | Сургалтын агуулга | Хугацаа /цаг/ | Хүрэх үр дүн |
|--|---|---------------|---|
| 1. | Нэг. Хууль, эрх зүйн мэдлэг олгох: | | |
| | 1.1.Улсын бүртгэлийн ерөнхий хууль 1.2.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль | 1 | Бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай хууль, эрх зүйн мэдлэг дээшилсэн байна. |
| | 1.3.Зөрчлийн тухай хууль, 1.4.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн талаар | 1 | |
| | 1.5.Гаалийн тухай хууль, гаалийн бүрдүүлэлтийн горимын талаар | 1 | |
| | 1.6.Монгол улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хууль, 1.7.Онцгой албан татварын тухай хууль | 1 | |
| 1.8.Даатгалын тухай хууль 1.9.Жолоочийн даатгалын тухай хууль | 1 | | |
| 2. | 2.1."Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам" | 0.5 | Бүртгэлийн үйл |

| | | | | |
|----|--|---|-----|--|
| | Хоёр. Дүрэм, журмын талаар мэдлэг олгох: | 2.2.Мэдээллийн аюулгүй байдал, төрийн байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох журмын тухай | 0.5 | ажиллагаанд холбогдох дүрэм, журмын хэрэгжилт сайжирсан байна. |
| | | 2.3.Олон улсын гэрээ, хэлэлцээрийн талаар | 1 | |
| 3. | Гурав. Норм, норматив, стандартын талаарх мэдлэг олгох: | 3.1.“Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг. 1-р хэсэг. Ерөнхий шаардлага. MNS 4410-1:2002” стандартын талаар | 0.5 | Салбарын холбогдох норм, норматив, стандартын мэдлэг сайжирсан байна. |
| | | 3.2.“Автотээврийн хэрэгсэл. Автомашин, чиргүүлийн хэмжээ. Нэр томьёо, тодорхойлолт MNS ISO 612:2012” стандартын талаар | 0.5 | |
| | | 3.3.“Автотээврийн хэрэгсэл.төрөл, нэр томьёо, тодорхойлолт MNS ISO 3833:2010”-ын талаар | 0.5 | |
| | | 3.4.Евро стандартын талаар | 0.5 | |
| | | 3.5.Автотээврийн хэрэгслийн таних тэмдгийн дугаар(VIN) -Агуулга ба бүтэц MNS ISO 3779:2010 | 1 | |
| | | 3.6.Автотээврийн хэрэгслийн - Дэлхийн үйлдвэрлэгчийг таних тэмдэг (WMI)-ийн код MNS ISO 3780:2010 | | |
| | | 3.7.Автотээврийн хэрэгслийн таних тэмдгийн дугаар (VIN) -байрлал ба бэхэлгээ MNS ISO 4030:2010 | | |
| | | 3.8.Монгол Улсад үйлдвэрлэсэн авто тээврийн хэрэгсэлд MNS ISO 3779:2010 (VIN) стандартыг хэрэглэх заавар MNS 6512:2015 | 0.5 | |
| | | 3.9.Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих шаардлага MNS 4598:2011 | | |
| | | 3.10.Хүнд даацын автотээврийн хэрэгсэл. Техникийн ерөнхий шаардлага. MNS 6278:2011 | 0.5 | |
| 4. | Дөрөв. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар: | 4.1.Эрх зүйн зөрчлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар | 1 | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдлэг дээшилсэн байна. |
| | | 4.2.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар | 1 | |
| 5. | Тав.Үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх талаар: | 5.1.Автотээврийн хэрэгслийн ашиглалт аюулгүй байдлын талаар | 0.5 | Үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан байна. |
| | | 5.2.Нотариат, худалдах, худалдан авах гэрээний талаар | 0.5 | |

| | | | | |
|----|----------------|---|--------|--|
| | | 5.3.Үйлчилгээний ажилтны ёс зүй, харьцааны соёлын талаар | 1 | |
| | | 5.4.Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын болон бүртгэлийн програм хангамжийн шинэчлэлийн талаар | 1 | |
| 6. | Үр дүнг үнэлэх | Сургалтад хамрагдсан мэргэжилтнүүдээс шалгалт авах | 1 | |
| 7. | Нийт цаг | | 17 цаг | |

Автотээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтнүүд нь дээрх хөтөлбөрийн агуулгын хүрээнд нийт 17 цагийн сургалтад хамрагдана.

-----ooOoo-----